

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.2. Төслийн танилцуулга мэдээлэл.....	3
1.2.1. Талбайн байршил	3
1.2.2. Ордын нөөц	5
1.3. Ил уурхайн ашиглалтын технологи.....	6
1.4. Ил уурхайн процесс	8
1.4.1. Шимт хөрс хуулалт	8
1.4.2. Өрөмдлөг	8
1.4.3. Тэсэлгээ.....	9
1.5. Баяжуулалтын технологи	9
1.6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө.....	9
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
2.1. Байгаль орчны онцлог	11
2.2. Нийгэм эдийн засаг	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	13
3.1. Агаарын чанар	13
3.2. Хөрсөн бүрхэвч	13
3.3. Гадаргын болон газрын доорх ус	13
3.4. Амьтны аймаг	13
3.5. Хүний эрүүл мэнд	14
3.6. Нийгэм эдийн засаг	14
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	15
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	18
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	21
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	23
Гэрээний дүнгээр.....	24
4.10. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	24
ДҮГНЭЛТ.....	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг 3
Зураг 2. Уурхайн хотхон, оффисын талбай..... 4
Зураг 3. Олборлолт, баяжуулалтын талбай 4
Зураг 4. Уурхайн ухаш, баяжуулалтын талбай 5
Зураг 5. Уурхайн сүүлийн жилийн байдлаарх ашиглалтын зураг 6
Зураг 6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний план зураг 10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг..... 5
Хүснэгт 2. Үйлдвэрийн нөөц 6
Хүснэгт 3. Ашиглалтын технологийн үндсэн элементүүдийн параметр..... 6
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим 7
Хүснэгт 5. Хуулах шимт хөрсний хэмжээ 8
Хүснэгт 6. Хуулах шимт хөрсний хэмжээ 8
Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг 15

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Хас металл” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011511015
Регистрийн дугаар	5887917
Хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Оранж плаза төвийн 502 тоот
Холбоо барих утас	7011-1819, 8801-1111

1.2. Төслийн танилцуулга мэдээлэл

1.2.1. Талбайн байршил

Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Даланжаргал сумын төвөөс зүүн хойш 40 км, Говь-сүмбэр аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 59 км, Өлзийт өртөөнөөс зүүн хойш 2 км-т, УБТЗ-ын 25-р зөрлөгөөс зүүн хойш 25 км зайд оршино.



Зураг 1. Талбайн байршилын зураг



Зураг 2. Уурхайн хотхон, оффисын талбай



Зураг 3. Олборлолт, баяжуулалтын талбай



Зураг 4. Уурхайн ухааш, баяжуулалтын талбай

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг

№	Газарзүйн солбицол		Талбай, га
1	108° 49' 17.62" E	46° 1' 57.33" N	123.84
2	108° 49' 17.62" E	46° 1' 23.65" N	
3	108° 48' 40.61" E	46° 1' 23.65" N	
4	108° 48' 40.61" E	46° 1' 40.66" N	
5	108° 48' 15.62" E	46° 1' 40.66" N	
6	108° 48' 15.62" E	46° 1' 23.65" N	
7	108° 48' 9.62" E	46° 1' 23.65" N	
8	108° 48' 9.62" E	46° 1' 57.33" N	


1.2.2. Ордын нөөц

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь төмрийн хүдрийн ордын геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр хүдрээр 114 980.96 тн, металлаар 50 491.5 тн, боломжтой (С) зэрэглэлээр хүдрээр 135 173.08 тн, металлаар 59 133.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр хүдрээр 250 154.04 тн, металлаар 109 624.8 тн-оор хүлээн авч бүртгэлжүүлсэн.

Үйлдвэрлэлийн нөөцийг уурхайн хүрээнд орж буй В+С зэргээр нийт 200.3 мян.тн хүдэрт тооцсон бөгөөд ашиглалтын явцад 3.19%-ийн хаягдал, 4.79%-ийн бохирдол үүсэхээр тооцоход үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ нийт 203.19 мян.тн байна.

Хүснэгт 2. Үйлдвэрийн нөөц

Түвшин	Бодитой В нөөц, тн	Боломжтой С нөөц, тн	Бохирдлын хэмжээ, тн	Хаягдлын хэмжээ, тн	Үйлдвэрлэлийн нөөц, тн
1295->1285	-	52	2	2	52.8
1285->1275	12,545	10,714	1,114	778	23,595.1
1275->1265	40,577	35,524	3,644	2,545	77,198.8
1265->1255	45,687	32,441	3,741	2,613	79,255.5
1255->1245	16,172	6,592	1,090	761	23,092.5
Нийт	114,981	85,323	9,591	6,700	203,194.7



Зураг 5. Уурхайн сүүлийн жилийн байдлаарх ашиглалтын зураг

1.3. Ил уурхайн ашиглалтын технологи

Ордын геологи болон уул техникийн нөхцөл талаас гадаад овоолго бүхий тээвэртэй ашиглалтын системийн хэрэглэх нь хамгийн зохистой шийдэл болох юм. Иймээс хөрсийг гадаад овоолгод хураах тээвэртэй ашиглалтын технологийг сонгон авсан. Уулын ажлын ерөнхий чиглэл дээрээс доош чиглэсэн байна.

Хүснэгт 3. Ашиглалтын технологийн үндсэн элементүүдийн параметр

№	Ашиглалтын технологийн элементүүд	Хэмжих нэгж	Параметрууд
1	Хөрс, хүдрийн ажлын доголудын өндөр	м	5
2	Хөрс, хүдрийн тэсэлгээний доголын өндөр	м	5
3	Ажлын бус доголын өндөр	м	10
4	Уурхайн хажуугийн өнцөг	өнцөг	41-44
5	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	өнцөг	50
6	Ажлын доголын хажуугийн өнцөг	өнцөг	50
7	Аюулгүйн бермийн өргөн	м	3.5
8	Ажлын талбайн хамгийн бага өргөн	м	25
9	Хүдрийн хаягдал	%	3.19
10	Хүдрийн бохирдол	%	4.79

Уурхайн эцсийн дизайн

- Аюулгүйн бермийн өргөн 3.5 м
- Ажлын бус доголын өндөр 10 м
- Ажлын доголын өндөр 5 м
- Доголын хажуугийн өнцөг 50 град
- Замын өргөн 10 м
- Замын налуу 8%
- Хамгийн бага ажлын талбайн өргөн 20 м

Эцсийн уурхай нь 138-236 м урт, 81-133 м өргөн бөгөөд хамгийн их гүн нь 36 м байна.

Ажиллах горим. Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй 350 хоног ажиллана. Үлдсэн 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар тооцов. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Ил уурхайн ажиллах горимыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Нэгж	Утга
Уурхайн жилд ажиллах хоног		
Календарийн хоногийн тоо	хоног	365
Баяр ёслол, цаг агаарын саатал, сул зогсолт	хоног/жил	15
Жилд ажиллах хоног	хоног/жил	350
Жилд ажиллах цаг	цаг/жил	8400
Ээлжийн зохион байгуулалт		
Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж/хон	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг/ээлж	12
Засвар үйлчилгээний цаг		
Төлөвлөгөөт их засвар үйлчилгээ	цаг/жил	819
Урсгал засвар үйлчилгээ	цаг/жил	441
Нийт засвар үйлчилгээ	цаг/жил	1260
Техникийн бэлэн байдал	%	85%
Ээлжийн цаг ашиглалт		
Үзлэгийн хугацаа	мин/ээлж	15
Ээлж солилцох хугацаа	мин/ээлж	10
Хоолны цаг	мин/ээлж	60
Ул цэвэрлэх, тавцан засах, шилжилт хийх хугацаа	мин/ээлж	20
Бүтээлгүй ажиллах нийт хугацаа	цаг/ээлж	1.75
Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг/ээлж	10.25
Ашиглалтын бэлэн байдал	%	85.4%
Хоногт цаг ашиглалт	цаг/хон	20.5
Ээлжинд хөдөлгүүр унтрах хугацаа	цаг/ээлж	1.0
Ээлжинд хөдөлгүүр ажиллах хугацаа	цаг/ээлж	11.0
Хөдөлгүүр ашиглалтын коэффициент	%	92%
Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн жилд ажиллах цаг		
Бүтээмж	%	90%
Хөдөлгүүр ажиллах цаг	цаг/жил	6545
Бүтээлтэй ажиллах цаг	цаг/жил	5489

1.4. Ил уурхайн процесс

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилгод бүтээмжийг хангах ёстой.

Уурхайд дараах процессууд явагдана:

- Шимт хөрс хуулалт
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Ухаж ачих
- Тээвэрлэх
- Овоолох

Уурхайд явагдах дээрх процессуудад ажиллах үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг захиалагчийн өгсөн техникийн даалгаврын дагуу сонгов.

1.4.1. Шимт хөрс хуулалт

Уурхайн ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 метр зузаантайгаар урьдчилан хуулна. Шимт хөрс хуулах ажилд бульдозер ашиглах бөгөөд бульдозероор хусаж түрэн хуримтлуулан автосамосвал дугуйт ачигчийн хослолоор ачиж тээвэрлэн шимт хөрсний тусгай овоолгод байршуулна.

Ингэж хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордын ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2 м байх бөгөөд хажуугийн өнцөг нь 28-33 градус байна. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна. Шимт хөрс хуулалтын ажилд Shantui-SD22 бульдозер ашиглана.

Хүснэгт 5. Хуулах шимт хөрсний хэмжээ

№	Эвдрэл үүсэх талбай	Хэмжээ, га	Шимт хөрсний хуулах зузаан, м	Хуулах шимт хөрсний хэмжээ, м ³
1	Ил уурхай	2.5	0.3	7,376
2	Хөрсний гадаад овоолго	4.4	0.3	13,200
3	Зам талбай	3.8	0.3	11,400
4	Барилга байгууламж	5.8	0.3	17,400
Дүн		16.46		49,376

1.4.2. Өрөмдлөг

Уурхайн өрөмдлөгийн ажилд Atlas Copco DM45 маркийн 150-229 мм диаметртэй өрмийн машин ашиглана. Өрөмдлөгийн цооног нь 6.2 метр гүнтэй, 165 мм диаметртэй байна. Уурхайн ашиглалтын 4 жилийн хугацаанд хөрс болон хүдрийн өрөмдлөгийн ажилд нийт 34.5 мянган тууш метр өрөмдлөгийн ажил хийнэ.

Хүснэгт 6. Хуулах шимт хөрсний хэмжээ

Үзүүлэлт	Нэгж	Atlas Copco DM45
Уурхайн жилд ажиллах хоног	хон	350
Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Техникийн бэлэн байдал	%	85%
Ашиглалтын бэлэн байдал	%	85%
Хөдөлгүүр ашиглалтын коэффициент	%	92%
Бүтээмж	%	90%
Хөдөлгүүрийн чадлаар нийт ажиллах хугацаа	цаг	6645
Бүтээл		
Өрмийн машины цагийн бүтээл	м/цаг	32
Ээлжийн бүтээл	м/ээлж	295
Хоногийн бүтээл	м/хон	590
Жилийн бүтээл	м/жил	175,644

1.4.3. Тэсэлгээ

Тэсэлгээний ажлыг хөрс болон хүдэрт аль альд нь 7 хоногт 1 удаа явуулна. Нийт тэсрэх бодисын 60% ANFO буюу энгийн тэсрэх бодис, үлдсэн 40%-д эмульсийн тэсрэх бодис ашиглана. Тэсрэх бодисын хувийн зарцуулалт хөрсөнд 0.46 кг/м^3 , харин хүдэрт 0.67 кг/м^3 байна. Тэсэлгээний хэрэгсэлд цооногийн детонатр, гадаргуун детонатр, өдөөгч, гал дамжуулах утас /Нонель/ зэргийг ашиглана. Тэсэлгээний ажлын тооцоог хөрс болон хүдэрт тус тусад нь тооцсон.

1.5. Баяжуулалтын технологи

Уурхайд баяжуулах үйлдвэр байгуулж 203.1 мян.тн төмрийн хүдрийг 2 шатны хуурай цэвэрлэгээтэй соронзон баяжуулалтаар баяжуулах бөгөөд 55.14%-ийн гарцтай, 54.73%-ийн баяжмалын чанартай, 72.34%-ийн металл авалттай 112.0 мян.тн баяжмал гарган авна.

Хуурай соронзон баяжуулах үйлдвэр нь жилд 300 хоног буюу 6120 цаг тасралтгүй 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана. Баяжуулах үйлдвэр нь жилд дунджаар 50,000 тн хүдэр боловсруулахаар төлөвлөж байгаа ба дээрх горимоор ажиллахад 1 цагт 8.17 тн хүдэр баяжуулна.

1.6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2024 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 163.32 мян.м^3 хөрс хуулж, 50 мян.тн хүдэр олборлон баяжуулж, 27.57 мян.тн баяжмал борлуулахаар байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

Даланжаргалан сум нь 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог.

“Өлзийт-ухаа” төмрийн хүдрийн ордын уурхай нь физик газарзүйн мужлалаараа Монголын дорнод талын их мужийн халхын дундад ба Дарьгангын мужид хамрагдана. Даланжаргалан сум нь Сайншандын суурьт болон давхаргат өндөрлөг тал, хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл- цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлийн дэд муж, Зүүнбаяны суурьт болон давхаргат өндөрлөг тал хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл- цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлийн дэд мужид хамаарагдана. Гадаргын өндөршилийн хувьд тус сумын нутаг нь элэгдэл эвдрэлд ихээхэн өртсөн дундаж, нам үлдэц уулс бүхий ухаа-гүвээт, толгодот, нугачаат тал бүхий гадаргатай. Районы гадарга нь толгодорхог уулархаг төрөлд хамаарах ба “Өлзийт-Ухаа” төмрийн хүдрийн орд нь далайн түвшнээс дээш 1225-1300 м өндөрт өргөгдсөн мөлгөрдүү оройтой тэгш талархаг гадаргуутай. Талбайн 20%-ийг уул толгод, 80%-ийг тал хээр эзэлнэ.

Дорноговь аймаг нь Монголын эрс тэс уур амьсгалтай, дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Хамгийн их халуун /300 ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -20-15 байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.

2.2. Нийгэм эдийн засаг

Дорноговь аймаг нь 1931 онд байгуулагдсан Улаанбаатар хотоос 450 км-т оршдог. Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг.

Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42.8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. Тус аймагт 2017 оны эцсийн байдлаар 20844 өрхөд 68606 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 1,5 хүн ногдож байна. Тэдний 61 хувь нь хот тосгонд, 15,2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Хүн амын 48,7 хувь нь эрэгтэйчүүд, 51,3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нэг өрхөд дунджаар 3,4 хүн ноогддог. Нийт 19,7 мянган ажиллагсад байгаа нь ажил эрхэлж байгаа нэг хүнд 2,6 хүн ноогдож байна.

Хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр тус аймаг улсын дунджаас дээгүүр байна. Нийт өрхийн 15,2 хувь, хүн амын 19,6 хувь нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой амьдарч байна.

Дорноговь аймгийн Даланжаргалан сум нь ардын хувьсгалын ялалтын дараахан буюу 1924 онд нутгийн захиргаадыг байгуулж эхлэх тэрхүү цаг дор БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор Хан-хэнтий уулын хошуунд Даланжаргалан нэртэйгээр

байгуулсан түүхтэй. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харъяалагдаж 1959 онд одоогийн төвлөрч байгаа “Цомог” хэмээх газарт суурьшжээ. Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-овоо гэсэн 5 багийн нийт 833 өрхөд 2625 хүн амьдардаг.

Суманд бүртгэлтэй ажилгүй 20 иргэн байна. Нийт ажилгүй иргэдийн 75,0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 1 хувийг дээд, 5 хувийг тусгай дунд, 61 хувийг бүрэн дунд, 26 хувийг бүрэн бус дунд, 7 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанар

Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Олборлолтын үед тоос дэгдэж агаарт сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороон дарагдах зэргээр эвдрэлд орно
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй байна.

3.3. Гадаргын болон газрын доорх ус

Өлзийт-Ухаагийн ордод 2019 онд хийгдсэн геологийн хайгуулын 20-88 метр хүртэлх гүнтэй нийт 44 ширхэг цооног өрөмдөх үед усжилттай байж болох цооног илрээгүй ба ашиглалтын талбайгаас хамгийн ойр орших уст цэг нь зүүн урд зүгт 2.3 км-т байрлах Өлзийтийн гар худаг юм. Тус худгийн тогтонги түвшин 1.7 м, ундарга нь 1.0 л/с, түвшний бууралт 0.5 м байлаа. Усны химийн найрлага нь гидрокарбонат-сульфат-кальци-магнийн төрлийн ус байдаг байна.

Төслийн хэмжээнд зам талбай, ногоон байгууламж, унд ахуйн хэрэглээны усыг зэргэлдээ байрлах “Мөнгөн хас шонхор” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зөөврөөр авч ашиглана. Үйлдвэрлэлийн процесс нь хуурай соронзон технологитой тул ус ашиглалт байхгүй байна.

Иймд төслийн үйл ажиллагаа, ашиглалтын технологи зэргээс усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

3.4. Амьтны аймаг

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах осолгүй ажлыг байнга хийнэ.

3.5. Хүний эрүүл мэнд

Төслийн үйл ажиллагаанаас уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллөөр дунд зэрэг байна.

3.6. Нийгэм эдийн засаг

Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн ордыг ашиглах төслөөс нийгэм эдийн засагт ажлын байх нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах зэргээр ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх нь боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2023 онд мэргэжлийн эрх бүхий “САУТ ВОЛИ” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 9,994,000 төг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг

Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,850,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	-
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,300,000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,800,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,044,000
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,000,000
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт		9,994,000

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: <ul style="list-style-type: none"> Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, бутлалт овоолго зэрэг газар шорооны ажил Ажилчдын суурин болон уурхайн олборлолтын үеийн газар шорооны ажил Уурхайн үйл ажиллагаанд буй ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох 	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу үзлэгт хамруулна.	Төсөлд ашиглагдах техник тоног төхөөрөмжид	ш	50.0	7	350.0	Ашиглалтанд гарахын өмнө	<ul style="list-style-type: none"> MNS 5013:2003 Бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 Дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага) MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентраци. MNS (ISO) 13688:2000 MNS 5620:2006 MNS 5623:2006 MNS 5388:2004 MNS 5389:2004
	Тээврийн хэрэгслээс гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргын шаардлагатай хэсгүүдийг хусах	Тээврийн зам, уурхайн ажлын үед	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			Олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлах	Уурхайн тээвэрлэлтийн зам дагуу	ш	80.0	5	400.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Гадаргын усыг авч ашигласнаар голын урсцын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх	ШТМ тээвэрлэх машиныг зориулалтын талбайд байршуулан орчмыг хатуу хучилттай болгох	Төслийн талбайд	м ²	600.0	-	600.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	<ul style="list-style-type: none"> Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль Ус нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай ЗГ-ын тогтоол
	Уурхайн олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад	Уурхайн тосгонд	-	2000.0	-	2000.0		

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.	газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж хөрсөнд нэвчихгүй ариун цэврийн байгууламж байгуулах							
Хөрс, ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, ШТМ, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрс, ургамлан бүрхэвчийг бохирдуулан талхагдуулах	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулах Олборлолтын ажил, овоолго, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас талбайн хөрсний эвдрэлийг аль болох бага байлгахад чиглэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтоогдсон ажлын зурваст байлгах	Төслийн хэмжээнд Уулын ажлын үед	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан Зардал тусгах шаардлагагүй.			Тухай бүрд Төсөл хэрэгжих явцад	<ul style="list-style-type: none"> MNS4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS4759:2014 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Ухсан нүх, карьерт амьтад орж үрэгдэх, дуу чимээний нөлөөллөөс үргэж дайжих	Уурхайн бүсэд хамгаалалтын хашаа барих, шувууны үүр барьж өгөх	Лицензийн талбайн ойр орчим болон орон нутагт		500.0		500.0	Төслийн хугацаанд	<ul style="list-style-type: none"> Амьтны тухай хууль
Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний зардал						3,850,000		

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тус онд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тухайн оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу ашиглалтын талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй байна.

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт төслийн талбайд ойр орших газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ. Дүйцүүлэн хамгаалах ажлуудыг гүйцэтгэх талбайн хэмжээний хувьд 4 жилээр төлөвлөж өгсөн бөгөөд тус онд төслийн талбайгаас зүүн зүгт 2 км-т орших 2051 м² эзэнгүй орхигдсон эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийж дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Дүйцүүлэн хамгаалах хийх талбай	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Төслийн талбайгаас зүүн зүгт 2 км-т байрлах талбайд	Орон нутгийн саналын дагуу заасан талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэнэ.	Даланжаргалан сумын нутагт	2051 м ²	0.35	Өөрсдийн тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.	Жил бүр	БОАЖЯ, Дорноговь аймгийн Байгаль орчны газраас гаргасан зөвлөмжийн дагуу
2	Тэрбум мод хөдөлгөөны хүрээнд	Уурхайн тосгоны урд хашаалсан талбайд	500 ширхэг мод тариалах	Төслийн талбайд	500 ш	15.0	Үйл ажиллагааны зардал	Хавар, Намар	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр

4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Өлзийт-Ухаа” төмрийн хүдрийн орд төслийн барилга, байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүргийг хүлээн ажиллана.

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1	Галын аюул	Агуулахын байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт) галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих (галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулах самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл...)	Объектын доторх ашигтай талбайгаас хамаарч 80 м ² ихгүй талбайд 1-г байршуулна.	3	100.0	300.0	Жилд нэг удаа	<ul style="list-style-type: none"> Гамшгаас хамгаалах тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм MNS 6576:2016 Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага MNS 5566:2020 Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
		Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах хэрэгслийн хугацаа, ажиллагаанд хяналт тавьж шалгах	Уурхайн үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэнд	-	ХАБ, дотоод хяналтын ажилтан хяналт тавина.	Тогтмол		
		Галаас сэргийлэх арга хэмжээ, заавар зөвлөмжийг байнга өгч байх	Ажилчдын тосгон, гал тогоо	-				

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
2	Гамшиг, осол аюул	Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Зохион байгуулах	-	ХАБ, дотоод хяналтын ажилтан хяналт тавина.	2024 онд	Гамшигаас хамгаалах тухай хууль	
		-						
		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах		-	ХАБ инженер хариуцан мөрдүүлнэ.			Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
Аюултай болон хортой бодис, материалыг хадгалалт, ашиглалтын үед аюулгүй ажиллагааны болон осол аваарын үед авах арга хэмжээний дарааллыг тогтоож, түүнийг мөрдөж ажиллах								
3	Хөдөлмөр аюулгүй байдал	Ажилчид гэмтэж, бэртэхэд анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, эм, ариутгалын нэг удаагийн хэрэгслийг бэлэн байлгах	Төслийн хугацаанд	-	1000.0		1-р улиралд	Хөдөлмөр аюулгүй ажиллагааны журам
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал					1,300,000			

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Ахуйн хог хаягдал	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулж сумын	Төслийн талбай	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Гэрээт хугацааны дагуу	<ul style="list-style-type: none"> “Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
	нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөн зайлуулах						<ul style="list-style-type: none"> БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4
	Хог хаягдлын төлбөрөө төлөх						
Аюултай хог хаягдал	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг Багахангай дүүрэгт байрлах “Алтан оршихуй” ХХК-ийн хаягдал тос масло боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан нийлүүлнэ.	Хаягдал тос масло	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Төслийн хугацаанд	<ul style="list-style-type: none"> “Хог хаягдлын тухай хууль” БОАЖС-ын 2018 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх.	Хогийн цэгээс	-	800.0		Дорноговь аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэх	
	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис, худалдаж авах зардал	Ахуйн бохир	-	1000.0		Жил бүр	
Хог хаягдлын менежментийн зардал				1,800,000			

4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Тайлбар	Баримтлах стандарт
	1	2	3	4	5	6	7
УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ							
1	~ Усны ерөнхий химийн шинжилгээ (Усны рН, цахилгаан дамжуулах	Унд ахуйн хэрэглээнд	Жилд 2 удаа	120.0	240.0	Дорноговь аймгийн	<ul style="list-style-type: none"> MNS 4586:1998

	<p>чадвар нүүрстөрөгчийн исэл CO₃, хүчил HCO₃, кальци Ca, хлор Cl)</p> <p>~ Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ (кали K, магни Mg, сода Na, хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag)</p> <p>~ Хими бактерилогийн бүрэн шинжилгээ</p>	<p>ашиглагдах худагт</p> <p>1 цэгт</p>				<p>ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ</p>	<p>Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага</p> <ul style="list-style-type: none"> • MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ • MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ							
2	<p>~ Нефть, нефтийн бүтээгдэхүүн,</p> <p>~ Хар тугалга, Азот, Фосфор, Усан мандал, Кальци, Магни, Кали, Магни, Хлор, Сульфат, Карбонат, Гидрокарбонат, Ариун цэврийн тоо, Коли- титр, Перфрингеститр</p>	<p>Мониторингий н цэгүүдээс</p> <p>N 46°1'58.9"</p> <p>E 108°48'31.8"</p> <p>N 46°1'31.29"</p> <p>E 108°49'57.2"</p> <p>Нийт 2 цэгт</p>	<p>Жилд 2 удаа</p>	130.0	260.0	<p>Дорноговь аймгийн ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> • MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт • MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ							
3	<p>~ Тоосжилт (PM10, PSM, PM25)</p> <p>~ Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын давхар исэл, Аммиак г.м</p>	<p>Мониторингий н цэгүүдээс</p> <p>N 46°1'35.0"</p> <p>E 108°49'7.49"</p> <p>N 46°2'21.79"</p> <p>E 108°49'21.79"</p> <p>Нийт 2 цэгт</p>	<p>Жилд 2 удаа</p>	272.0	544.0	<p>Дорноговь аймгийн ЦУОШГ-аар гүйцэтгүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> • MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага • MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага • MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга

УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						
~	Хяналт шинжилгээ хийх талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлох	Мониторингийн н цэгүүдээс N 46°1'57.28" E 108°49'12.54" N 46°1'16.13" E 108°49'42.77" <i>Нийт 2 цэгт</i>	Жилд 1 удаа	500.0	Мэргэжлийн ургамал судлаачаар гүйцэтгүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох
Орчны хяналт, шинжилгээний зардал				2,044,000		

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
			2024 он				
			I- улирал	II- улирал	III- улирал	IV- улирал	
1	Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг танилцуулах	-	-	+	-	-	Байгаль орчны ажилтан
2	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	-	Үйл ажиллагааны турш				Уурхайн дарга, уулын инженер, байгаль орчны ажилтан
3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн явцын талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзаж танилцуулах	1000.0	-	+	-	+	Байгаль орчны ажилтан
4	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх	-	+	+	+	+	
5	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах, тэдний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд	-	+	+	+	+	Удирдах албан тушаалтан

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
			2024 он				
			I- улирал	II- улирал	III- улирал	IV- улирал	
	учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг гэрээнд тусгах						
6	Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компанийн хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Хамтран ажиллах гэрээгээр	+	+	+	+	
7	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гэрээний дүнгээр	-	-	+	+	Удирдах албан тушаалтан, байгаль орчны ажилтан
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө			1000.0				

4.10. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сум, багийн нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн газар дээр нь танилцуулах	Уулзалт хийнэ.	Уурхайн үйл ажиллагаа	Орон нутгаас тогтоосон хугацаанд	Зардал шаардлагагүй.	Уурхайн дарга болон компанийн захирал	Төслийн талбайд
2	Дорноговь аймгийн ЗД, ИНХ-ын төлөөлөгчид, Даланжаргалан сумын ЗДТГ-ын, Дорноговь аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулж санал авах		БОМТ биелэлтийн танилцуулга				ЗДТГ-ын хурлын танхим

ДҮГНЭЛТ

“Хас металл” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт MV-021469 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өлзийт Ухаа” төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийг 2023 оноос олборлолтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Тус онд уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай уялдуулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **9,994,000** төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000702480968

Системийн огноо/System Date: 2024.04.04 17:01:28

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5111517552	ЮУ БИ ЭКУПМЕНТ	5,000,000.00 MNT	1.00
/ Таван сая төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	90	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа	5,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-5887917 Хас метал байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр 2024 он

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)